



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны 01 сарын 10 өдөр

Дугаар 1

Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 2024 оны 01 дүгээр сард Эдийн засгийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай


Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын даргын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 2024 оны 01 дүгээр сард хэлэлцэх асуудлын дараалал тогтоох тухай” 221 дүгээр захирамжид заасан Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэх цаглаварыг хавсралтаар баталсугай.

2. Хуульд хэлэлцэх хугацааг тусгайлан заасан асуудал болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэхэд энэ цаглавар хамаарахгүй.

3. Энэ тогтоолын биелэлтийг хангаж, хэлэлцэх асуудлын бэлтгэл хангахыг Улсын Их Хурлын Тамгын газар (Д.Энхбат)-т үүрэг болгосугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ц.ЦЭРЭНПУНЦАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ 2024 ОНЫ 01 ДҮГЭЭР САРД ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ЦАГЛАВАР

Төслийн нэр	Хуулийн төслийн хүрээнд хийгдэж ажил	2024.01.02-01.05						2024.01.08-01.12						2024.01.15-01.19			
		Даваа 04	Мягмар 05	Лхагва 06	Пүрэв 07	Баасан 08	Даваа 11	Мягмар 12	Лхагва 13	Пүрэв 14	Баасан 15	Даваа 18	Мягмар 19	Лхагва 20	Пүрэв 21	Баасан 22	
Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар, 2023.12.22-ны өдөр/;	Хэлэлцэх эсэх																



Төслийн нэр	Хуулийн төслийн хүрээнд хийгдэж ажил	2024.01.02-01.05						2024.01.08-01.12						2024.01.15-01.19					
		Даваа 04	Мягмар 05	Лхагва 06	Пүрэв 07	Баасан 08	Даваа 11	Мягмар 12	Лхагва 13	Пүрэв 14	Баасан 15	Даваа 18	Мягмар 19	Лхагва 20	Пүрэв 21	Баасан 22			
“Аж ахуйн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог хязгаарлах тухай” УИХ-ын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, 2022.12.13/;	Хэлэлцэх эсэх	Эдийн засгийн байнгын хороо																	
		Нэгдсэн хуралдаан																	
	Ажлын дэд хэсэг																		
	Ажлын хэсэг																		
	Анхны хэлэлцүүлэг	Эдийн зсгийн байнгын хороо																	
		Нэгдсэн хуралдаан																	
	Ажлын дэд хэсэг																		
	Ажлын хэсэг																		
	Эцсийн хэлэлцүүлэг	Эдийн зсгийн байнгын хороо																	
		Нэгдсэн хуралдаан																	
	Эцэслэн батлах	Нэгдсэн хуралдаан																	

Төслийн нэр	Хуулийн төслийн хүрээнд хийгдэж ажил	2024.01.02-01.05						2024.01.08-01.12						2024.01.15-01.19					
		Дагаа 04	Мягмар 05	Лхагва 06	Пүрэв 07	Баасан 08	Дагаа 11	Мягмар 12	Лхагва 13	Пүрэв 14	Баасан 15	Дагаа 18	Мягмар 19	Лхагва 20	Пүрэв 21	Баасан 22			
“Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулахыг түр хориглох, тэдгээрийн үр ашиг менежментийг сайжруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл; /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 12 гишүүн, 2022.06.03/;	Хэлэлцэх эсэх																		
		Эдийн засгийн байнгын хороо																	
		Нэгдсэн хуралдаан																	
	Ажлын дэд хэсэг																		
	Ажлын хэсэг																		
	Анхны хэлэлцүүлэг																		
	Ажлын дэд хэсэг																		
	Ажлын хэсэг																		
	Эцсийн хэлэлцүүлэг																		
Эцэслэн батлах																			





МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ

2024 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 2

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

Т.Энхтүвшин

-Улсын Их Хурлын гишүүн

Ажлын хэсгийн гишүүд:

Б.Баттөмөр

-Улсын Их Хурлын гишүүн

Н.Ганибал

-Улсын Их Хурлын гишүүн

Т.Доржханд

-Улсын Их Хурлын гишүүн


Ч.Ундрэм

-Улсын Их Хурлын гишүүн

2. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын мэргэжлийн албан хаагчдыг ажиллуулахыг Ажлын хэсэг (Т.Энхтүвшин)-т зөвшөөрсүгэй.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ЦЭРЭНПУНЦАГ





МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 3

Улаанбаатар хот


Нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулах бэлтгэл хангах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйл, Төрийн албаны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 43 дугаар зүйл, Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсгийг тус тус үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн албан тушаалд нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулах бэлтгэл хангаж, нэр дэвшигчийн дэлгэрэнгүй танилцуулга болон тус албан тушаалд тавигдах нийтлэг, тусгай шаардлагыг тусгасан мэдээлэл авах маягтын загвар боловсруулахыг Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцагт даалгасугай.

2.Хууль тогтоомжоор эрх олгогдсон этгээд Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн албан тушаалд нэр дэвшигчийг санал болгож, тухайн албан тушаалтан томилогдох хүртэл хугацаанд холбогдох хуульд заасны дагуу Монголбанкны Дэд ерөнхийлөгч Ганболдын Энхтайванаар Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн үүргийг түр орлон гүйцэтгүүлсүгэй.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ц.ЦЭРЭНПУНЦАГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 4

Улаанбаатар хот


Ажлын хэсгийн удирдамж батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэг, Улсын Их Хурлын даргын 2024 оны 25 дугаар захирамжийг тус тус үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.“Газрын тухай болон Ашигт малтмалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, газрын зөвшөөрөл олголт, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олголт, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төсөвт төвлөрүүлэх үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж санал, дүгнэлт гаргах, хянан шалгах түр хороо байгуулах бэлтгэл хангах” үүрэг бүхий ажлын хэсгийн удирдамжийг хавсралтаар баталсугай.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эдийн засгийн байнгын хороо (Ц.Цэрэнпунцаг)-нд даалгасугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ц.ЦЭРЭНПУНЦАГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны 04 сарын 03 өдөр

Дугаар 5

Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 04 дүгээр сард Эдийн засгийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай


Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн “Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 04 дүгээр сард хэлэлцэх асуудлын дараалал тогтоох тухай” 42 дугаар захирамжид заасан Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэх цаглаварыг хавсралтаар баталсугай.

2. Хуульд хэлэлцэх хугацааг тусгайлан заасан асуудал болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэхэд энэ цаглавар хамаарахгүй.

3. Энэ тогтоолын биелэлтийг хангаж, хэлэлцэх асуудлын бэлтгэл хангахыг Улсын Их Хурлын Тамгын газар (Д.Энхбат)-т үүрэг болгосугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ц.ЦЭРЭНПУНЦАГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 6

Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 05 дугаар сард Эдийн засгийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай


Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 05 дугаар сард хэлэлцэх асуудлын дараалал тогтоох тухай” 66 дугаар захирамжид заасан Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэх цаглаварыг хавсралтаар баталсугай.

2. Хуульд хэлэлцэх хугацааг тусгайлан заасан асуудал болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэхэд энэ цаглавар хамаарахгүй.

3. Энэ тогтоолын биелэлтийг хангаж, хэлэлцэх асуудлын бэлтгэл хангахыг Улсын Их Хурлын Тамгын газар (Д.Энхбат)-т үүрэг болгосугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ц.ЦЭРЭНПУНЦАГ

